

ДОРНОД АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2020 ОНЫ ЭХНИЙ 11 ДҮГЭЭР САРД БҮРТГЭГДСЭН  
ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ГАРАЛТ, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, АНХААРАХ  
АСУУДЛУУДЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2020.12.01

Хэрлэн сум.

### НЭГ. ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 11 дүгээр сард 390 холбогдогчтой, 1467.3 төгрөгийн хохиролтой, 472 гэмт хэрэг бүртгэгдэж 151 хэргээр буюу 24.2 хувиар урьд оны мөн үеэс буурчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 55 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 11.9 хувиар өссөн байна. Гэмт хэргийн улмаас 25 хүн нас барж, 218 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүн 6 буюу 19.3 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 5 буюу 22.7 хувиар өссөн байна. Иргэд аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирлын 580.8 төгрөг буюу 39.9 хувийг нөхөн төлүүлжээ.

**Гэмт хэргийн гаралт:** - Хэрлэн сумын 3, 10, 11-р багууд, Баян-Уул сумдад өсч,

Хэрлэн сумын 1, 2, 4, 5, 6, 8, 9 дүгээр багууд, Дашбалбар, Чулуунхороот, Чойбалсан, Баяндун, Гурванзагал, Сэргэлэн, Цагаан-Овоо, Баянтүмэн, Булган, Хөлөнбуйр, Матад, Халх гол сумдуудад буурч, Хэрлэн сумын 7-р багт ижил түвшинд байна.

**Үйлдэгдсэн байдлаар:** - Бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 22 бүртгэгдэж 3 буюу 12%, Хүүхэд оролцсон гэмт хэрэг 2 бүртгэгдэж нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6 буюу 75%, Мансуурсан үедээ үйлдсэн гэмт хэрэг 1 бүртгэгдэж 1 буюу 50 хувиар, Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 16 бүртгэгдэж 11 буюу 40.7 хувиар тус тус буурчээ.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 160 бүртгэгдэж 28 буюу 21.1%, Эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 48 бүртгэгдэж 3 буюу 6.6 хувиар, Урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс дахин гэмт хэрэгт 96 хүн холбогдсон нь 67 буюу 23 дахин хувиар тус тус өссөн байна.

**Үйлдэгдсэн газраар:** - Байгууллага аж ахуй нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг 28 бүртгэгдэж 5 буюу 21.7 хувиар, Авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 47 бүртгэгдэж 8 буюу 20.5 хувиар өсч,

Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 62 бүртгэгдэж 1 буюу 1.5 хувиар, Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 24 бүртгэгдэж 33 буюу 57.8 хувиар, бэлчээрт үйлдэгдсэн гэмт хэрэг 26 бүртгэгдэж 35 буюу 57.3 хувиар, хөдөө хээр үйлдэгдсэн гэмт хэрэг 49 бүртгэгдэж 56 буюу 53.3 хувиар, бусад газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 88 бүртгэгдэж 187 буюу 68 хувиар тус тус буурсан байна. Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 148 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.

**Хэргийн төрлөөр:** - Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 178 бүртгэгдэж 3 буюу 1.7%, Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 14 бүртгэгдэж 1 буюу 7.6%, хөрөнгө завших гэмт хэрэг 9 бүртгэгдэж 3 буюу 50%, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 4 бүртгэгдэж 1 буюу 33.3%, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3 бүртгэгдэж 1 буюу 50%, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг 9 бүртгэгдэж 9 дахин, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 44 бүртгэгдэж 6 буюу 15.7%, бусад төрлийн гэмт хэрэг 16 бүртгэгдэж 2 буюу 14.2 хувиар тус тус өсч,

Хүнийг алах гэмт хэрэг 6 бүртгэгдэж 3 буюу 33.3%, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 1 бүртгэгдэж 1 буюу 50 %, Залилах гэмт хэрэг бүртгэгдэж 35 бүртгэгдэж 9 буюу 20.4 хувь, дээрэмдэх гэмт хэрэг 3 бүртгэгдэж 4 буюу 57.1 хувиар, Гээгдэл эд зүйл, алдуул мал завших гэмт хэрэг 4 бүртгэгдэж 6 буюу 60%, Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг 1 бүртгэгдэж 2 буюу 66.6%, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах

гэмт хэрэг 1 бүртгэгдэж 6 буюу 85.7 хувиар тус тус буурчээ, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт 1 бүртгэгдэж 2 буюу 66.6%, Авлигын эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдэж 7 буюу 87.5 хувиар тус тус буурчээ.

Хүнийг амь насыг болгоомжгүй хохироох, Халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг, мансууруулах эм сэтгэгдэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэргүүд өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна.

Хулгайлах гэмт хэрэг 135 бүртгэгдэж 119 буюу 46.8 хувиар буурч, үүнээс: хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 78 бүртгэгдэж 27 буюу 25.7 хувиар, Мал хулгайлах гэмт хэрэг 57 бүртгэгдэж 92 буюу 61.7 хувиар тус тус буурсан байна.

**Үйлдэгдсэн цаг хугацаагаар нь:** 22-06 цагийн хооронд 160 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 33.8%, 06-14 цагийн хооронд 85 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 18%, 14-19 цагийн хооронд 127 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 26.9%, 19-22 цагийн хооронд 100 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 21.1%-ийг эзэлж байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 80 буюу 16.9 хувь нь Баасан гарагт, 59 буюу 12.5% Даваа гарагт, 61 буюу 12.9% нь Мягмар, Лхагва гарагт 77 буюу 16.3% нь Пүрэв гарагт 61 буюу 12.9% нь Бямба гарагт, 76 буюу 16.1% нь Ням гарагт 58 буюу 12.2 хувиар тус тус үйлдэгджээ.

**Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийг байршлаар нь:** Хэрлэн сумын 6-р багт 25 буюу 15.6%, 1, 3, 7-р багуудад тус бүр 10 буюу 6.2% , Цагаан-Овоо, Баяндун, Дашбалбар, сумдуудад тус бүр 3 буюу 1.8%, 4 буюу 2.5 хувь нь Булган, Гурванзагал, Чойбалсан, Чулуунхороот, Матад сумдад, 9-р баг, Баян-Уул, Хөлөнбуйр, сумдад 6 буюу 3.7%, 5,11-р багууд, Халхгол сум сумдад тус бүр 2 буюу 1.2%, 4-р багт 12 буюу 7.5% 2-р багт 13 буюу 8.1%, 10-р багт 21 буюу 13.1%, Баянтүмэн суманд 5 буюу 3.1 хувиар тус тус бүртгэгджээ.

## ХОЁР. ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 11 дүгээр сард 18863 зөрчил илрүүлсэн нь 1112 зөрчлөөр буюу урьд оны мөн үеэс 6.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт 17567 иргэнийг 803603.5 төгрөгөөр торгож, 745 жолоочийг торгож-тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 377 хүнийг захиргааны журмаар /үүнээс:114 буюу 38.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 215 буюу 57% нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон/ баривчлуулан шийдвэрлэжээ. Согтууруулах ундаа хэрэглэн зөрчил гаргасан 3920 иргэнийг эрүүлжүүлсэн нь 337 буюу 9.4 %-иар өссөн байна.

### Зөрчлийн үйлдэгдсэн цаг хугацаа, гарагийг нийт зөрчилд эзлэх хувиар:

- |                                  |                                  |
|----------------------------------|----------------------------------|
| - Ням гарагт 1825 буюу 9.6 %,    | - Лхагва гарагт 2994 буюу 15.8%, |
| - Баасан гарагт 3386 буюу 17.9%, | - Даваа гарагт 2546 буюу 13.4%,  |
| - Пүрэв гарагт 2907 буюу 15.4 %, | - Бямба гарагт 2184 буюу 11.5%,  |
| - Мягмар гарагт 3021 буюу 16%,   |                                  |
| - 13-18 цагт 7470 буюу 39.6%,    | - 19-24 цагт 7090 буюу 37.5%,    |
| - 06-12 цагт 3895 буюу 20.6%     | - 01-05 цагт 408 буюу 2.1%.      |

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үедээ зөрчил гарган **3920 иргэн саатуулагджээ.** Үүний 264 буюу 6.7% нь эмэгтэй хүн, 6 буюу 0.1 хувийг хүүхэд эзлэж байна.

### нийгмийн байдлаар нь:

- Ажилгүй 3889 буюу 99.2%
- Хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч 6 буюу 0.1%

• Хувиараа хөдөлмөр эрхлэгч	8 буюу 0.2%
• Малчин	2 буюу 0.1%
• Төрийн албан хаагч	5 буюу 0.1%
• Бусад	10 буюу 0.2 %-г эзэлж байна.

**Эрүүлжүүлэгдсэн шалтгаанаар нь:**

• Бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан	<b>3312 буюу 84.4%</b>
• Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон	564 буюу 14.3 %
• Тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодсон	179 буюу 4.5%
• Хаана байгаагаа, очих газраа мэдэхгүй болсон	210 буюу 5.3 %
• Гудамж талбайд ухаангүй унтсан	2 буюу 0.1%
• Гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй	42 буюу 1%
• Бусад	17 буюу 0.4%

**Эрүүлжүүлэгдсэн газраар нь:**

• <b>Гэр, орон сууцнаас</b>	<b>2883 буюу 73.5%</b>
• Гудамж талбайгаас	564 буюу 14.3%
• Байгууллага, аж ахуйн нэгжээс	128 буюу 3.2 %
• Баар, цэнгээний газраас	43 буюу 1%
• Зочид буудлаас	52 буюу 1.3%.
• Бусад	250 буюу 6.3 % нь эрүүлжүүлэгджээ

**ГУРАВ. ДҮГНЭЛТ**

1. Бүртгэгдсэн гэмт хэргийн 33.8%, зөрчлийн 40.1%-ийг согтуугаар, гэмт хэргийн 3.3 %, зөрчлийн 4.1%-ийг гэр бүл, хүчирхийллийн улмаас үйлдэгджээ.

2. Нийт гэмт хэргийн 26.9 хувь нь **19-22 цагт**, зөрчлийн **39.6% нь 13-18 цагт** тус тус бүртгэгдэж, гэмт хэргийн **16.9%**, зөрчлийн **17.9 %** нь тус **бүр Баасан гарагт** үйлдэгджээ.

3. Гэмт хэргийн **31.3%**, зөрчлийн **20.6%**, саатуулсан хүний **73.5%** нь гэр, орон сууцанд, ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа нь хэрэг, зөрчлийн дийлэнх хувийг эзэлж байна.

4. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 68.7 % нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг, эрүүлжүүлэгдсэн хүний **84.4%**-ийг бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан зөрчил эзэлж байгаа ба, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчлийн **0.7** хувь нь согтуугаар үйлдэгджээ.

5 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, хөрөнгө завших, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг, хууль бусаар мод бэлтгэх, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг, бусад төрлийн гэмт хэргүүд өссөн үзүүлэлттэй байна.

**ДӨРӨВ: ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ**

1. Энэ оны эхний 11 дүгээр сарын байдлаар 472 эрүүгийн хэрэг бүртгэгдэж, илрээгүй 136 эрүүгийн хэрэг ажиллагаанд байна. Хэргийн илрүүлэлт 55 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 11.9 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа ба улсын хэмжээнд 9 дүгээр байр эзэлж байгаа эерэг үзүүлэлттэй байна. Жилийн эцсийн тайлан мэдээ гарахад 1 сар орчим хүрэхгүй хугацаа үлдсэн байх тул хэргийн илрүүлэлтийг 60 хувь хүртэлх ахиулах чиглэлээр ажиллагаанд байгаа эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргүүдийн илрүүлэх чиглэлээр тодорхой төрлийн ажлыг зохион байгуулж ажилла. / 2020.08.19-ны өдөр ЦЕГ-ын даргаас цахим хурлын үеэр өгсөн үүрэгт гэмт хэргийн илрүүлэлтийг орон нутагт 60.0 хувьд хүргэх чиглэл өгсөн/

2. Урьд өмнө нь ял шийтгэгдсэн хүмүүсээс дахин гэмт хэрэг үйлдсэн гэмт хэрэг 96 бүртгэгдэж 67 буюу 23 дахин хувиар өссөн үзүүлэлттэй байгаа тул Эрүүгийн Цагдаагийн тасаг, Мөрдөн байцаах тасгуудад гадуур шалгагдаж байгаа этгээдүүдэд хяналт тавьж ажиллах.
3. Баг, сум хариуцсан хэсгийн байцаагч, төлөөлөгч нар тухайн баг дээр үйлдэгдсэн эзэн холбогдогч нь тодорхойгүй гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллахгүй туйлын хангалтгүй байна. Иймд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргүүдэд түүвэр төлөвлөгөө гарган ажиллах шаардлагатай байна.
4. Хамтарсан багийн ажлыг эрчимжүүлэх, объект, субъектын судалгааг баяжуулах, эзэн холбогдогч нь илрээгүй хэргийг илрүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах.
5. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт 6 буюу 15.7 хувиар өссөн байна. Иймд 2020 оны 07-р сарын 01-ний өдрөөс улсын хэмжээнд зохион явагдаж байгаа “Яараад яахав дээ” аяныг иргэдэд сурталчлах, зам тээврийн ослын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион явуулан ажиллах.

Та бүхний ажилд амжилт хүсье.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗАР